

# ЧОЙБАЛСАН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН III АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

2023-2024 оны хичээлийн жил

Хугацаа: 60 минут

Нийт 18 оноо

анги ..... овог..... нэр.....

НЭГ. УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

## А ХУВИЛБАР

### ЭЭЖИЙГ УЙЛУУЛСАН ЧИХЭР

Халиун талх авахаар хүнсний дэлгүүр ороход тэндхийн сайхан амттай чихэр, шоколад нүдэнд туслаа. Ээжийнх нь өгсөн мөнгө яг л талхаа аваад таарна. Амттанг хараад идмээр санагдаад, хорхой хүрээд болдоггүй ээ. Тэсэлгүй нэг жижиг ууттай чихэр аваад халаасандаа хийчихлээ. Тэгээд талхныхаа мөнгийг төлөөд гарах гэтэл:

Дэлгүүрийн хамгаалагч “Намайг дагана уу” гэсээр Халиуныг нэг жижиг өрөөнд дагуулж ороод түүний чихэр аваад халаасандаа хийж байгаа бичлэгийг нь үзүүллээ. Тун удалгүй Халиуны ээж дуудагдан ирэв. Ээж нь түүний авсан чихрийн мөнгийг төлж дэлгүүрийн ах, эгч нараас учвлалт гуйлаа. Буцах замдаа ээж нь Халиунд чихэр, жимс худалдан авч өгөөд:

- Бусдын юмыг зөвшөөрөлгүй авдаг хүнийг хулгайч гэдэг юм. Миний охин юу хийснээ сайн эргэцүүлэн бодоорой гээд нулимсаа арчив.

#### 1. Халиунд ээж нь юуны мөнгө өгсөн бэ? /1 оноо /

- A. чихрийн мөнгө
- B. дуртай зүйлээ авах мөнгө
- C. талхны мөнгө

#### 2. Халиун яаж чихэр авсан бэ? /1 оноо/

- A. Талхныхаа мөнгөөр авсан.
- B. Мөнгө төлөхгүй нууцаар авсан.
- C. Дэлгүүрийн хамгаалагчаас гүйж авсан.

#### 3 “ Ярих “ гэсэн үгийн эсрэг утгатай үгийг сонгоорой. /1оноо/

- A. өгүүлэх
- B. шуугих
- C. сонсох
- D. хашгирах

#### 4. Тэсэлгүй нэг **ямар** ? ууттай чихэр аваад халаасандаа хийчихлээ. Асуултанд хариулагдах үгийг сонгоорой. \1оноо\

- A. жижиг
- B. амттай
- C. Сайхан
- D. том

ХОЁР . БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

#### 5. Дараах үгийн утгыг гарган өгүүлбэр зохион бичээрэй. \2оноо\ /арга , араг/

#### 6. Зургийг ажиглан хараад, сонгож хэрэглэх үгсийг ашиглан 50-60 үтгэй үлгэр зохион бичээрэй. / Зоноо /

**Сонгож хэрэглэх үгс:** Орчныг дүрслэх үг: Жижигхэн навчтай модны дэргэд, ойн захад, зуны халуунд, хүнээс зайдуу гэх мэт.

**Зарааг дүрслэх үг:** Мэргэн бөөдий, түнтгэр өвгөн түмэн жадтай, ухаантай зараа гэх мэт. **Үнэгийг дүрслэх үг:** Том чихтэй үнэг, шаргал үнэг, ховч үнэг, цагаан чихт үнэг гэх мэт



## А ХУВИЛБАР


### НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

1. **7082 онцолсон цифр ямар утгыг илэрхийлж байна вэ? / 1 оноо/**

- A. Нэгж      B. Мянга      C. Зуут

2. **2935 -г орны нэмэгдэхүүнээр зөв задлан бичээрэй / 1 оноо/**  
.....

3. **Дугуйн радиус нь аль нь вэ? / 1 оноо/**



- A. OA

- B. AM

- C. MA

4. **Дарааллынн зүй тогтлыг илрүүлж, дараагийн тоог ол. /1 оноо/**

1, 5, 3, 7, 5, ?

A. 7

B. 6

C. 4

D. 9

### ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

5.  $1\text{м}^2\text{дм} - 7\text{дм} =$  /2 оноо/


6. Батын чихмэл тоглоом 25 ширхэг, бөмбөг 35 ширхэг . /3 оноо/

- Өгөгдлийг хүснэгтэнд бүртгээрэй
- Баганан диаграмм байгуулаарай.

= 5 ширхэг бөмбөг дүрсэлнэ.

= 5 ширхэг чихмэл дүрсэлнэ.

Бөмбөг	
Чихмэл	



# ЧОЙБАЛСАН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН III АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

2023-2024 оны хичээлийн жил

Хугацаа: 60 минут

Нийт 18 оноо

анги ..... овог..... нэр.....

НЭГ. УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

## Б ХУВИЛБАР

### ЭЭЖИЙГ УЙЛУУЛСАН ЧИХЭР

Халиун талх авахаар хүнсний дэлгүүр ороход тэндхийн сайхан амттай чихэр, шоколад нүдэнд туслаа. Ээжийнх нь өгсөн мөнгө яг л талхаа аваад таарна. Амттанг хараад идмээр санагдаад, хорхой хүрээд болдоггүй ээ. Тэсэлгүй нэг жижиг ууттай чихэр аваад халаасандаа хийчихлээ. Тэгээд талхныхаа мөнгийг төлөөд гарах гэтэл:

Дэлгүүрийн хамгаалагч “Намайг дагана уу” гэсээр Халиуныг нэг жижиг өрөөнд дагуулж ороод түүний чихэр аваад халаасандаа хийж байгаа бичлэгийг нь үзүүллээ. Тун удалгүй Халиуны ээж дуудагдан ирэв. Ээж нь түүний авсан чихрийн мөнгийг төлж дэлгүүрийн ах, эгч нараас училалт гуилаа. Буцах замдаа ээж нь Халиунд чихэр, жимс худалдан авч өгөөд:

- Бусдын юмыг зөвшөөрөлгүй авдаг хүнийг хулгайч гэдэг юм. Миний охин юу хийснээ сайн эргэцүүлэн бодоорой гээд нулимсаа арчив.

#### 1. Халиун дэлгүүрээс юу авах гэж явсан бэ? /1 оноо /

- A. чихэр авахаар
- B. дуртай зүйлээ авахаар
- C. талх авахаар

#### 2. Халиун яаж чихэр авсан бэ? /1 оноо/

- A. Талхныхаа мөнгөөр авсан.
- B. Мөнгө төлөхгүй нууцаар авсан.
- C. Дэлгүүрийн хамгаалагчаас гуйж авсан.

#### 3 “ Ярих” гэсэн үгийн ойролцоо утгатай үгийг сонгоорой. /1оноо/

- A. чагнах
- B. үзэх
- C. сонсох
- D. хэлэх

#### 4. Ээжийнх нь өгсөн **юу?** яг л талхаа аваад таарна. Асуултанд хариулагдах үгийг сонгоорой. \1оноо\

- A. мөнгө
- B. чихэр
- C. талх
- D. амттан

ХОЁР . БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

#### 5. Дараах үгийн утгыг гарган өгүүлбэр зохион бичээрэй. \2 оноо\

/сэрх , сэрэх/

.....  
.....  
.....

#### 7. Зургийг ажиглан хараад, сонгож хэрэглэх үгсийг ашиглан 50-60 үтгэй үлгэр зохион бичээрэй. / Зоноо /

**Сонгож хэрэглэх үгс:** Орчныг дүрслэх үг: Жижигхэн навчтай модны дэргэд, ойн захад, зуны халуунд, хүнээс зайдуу гэх мэт.  
**Зарааг дүрслэх үг:** Мэргэн бөөдий, түнтгэр өвгөн түмэн жадтай, ухаантай зараа гэх мэт. **Үнэгийг дүрслэх үг:** Том чихтэй үнэг, шаргал үнэг, ховч үнэг, цагаан чихт үнэг гэх мэт



## Б ХУВИЛБАР

### НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР


1. 7082 онцолсон цифр ямар утгыг илэрхийлж байна вэ? / 1 оноо/

- А. Нэгж      Б. Аравт      В. Зуут

2. 2945 -г орны нэмэгдэхүүнээр зөв задлан бичээрэй / 1 оноо/

---

3. Дугуйн диаметр нь аль бэ? / 1 оноо/



- A. МА  
Б. ОА  
В. ОМ

4. Дарааллын зүй тогтлыг илрүүлж, дараагийн тоог олоорой. /1 оноо/

- 1, 6, 3, 8, 5 ?  
А. 6      Б. 10      В. 4      Г. 9

### ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

5.  $7\text{см}^2\text{мм} - 5\text{мм} =$  /2 оноо/

6. Ангид 30 ширхэг ширээ, 15 ширхэг сандал байв . /3 оноо/


- Өгөгдлийг хүснэгтэнд бүртгээрэй.
- Баганан диаграмм байгуулаарай.

= 5 ширхэг ширээ дүрсэлнэ.



= 5 ширхэг сандал дүрсэлнэ.

Ширээ	
Сандал	



Зөв хариулт:

## МОНГОЛ ХЭЛ

Даалгаврын тоо	А хувилбар	Б Хувилбар	Онооны тайлбар
1	В	В	1оноо
2	Б	Б	1оноо
3	В	Г	1оноо
4	А	А	1оноо
5	арга- ухаан араг- давар	сэрг- ямаа сэрэх -унтаж сэрэх	2оноо
6	Үлгэр зохиосон байдал Алдаа тоолох		Үлгэр-2оноо Зөв бичиг 1 /алдаа- 0.1 оноо хасах/

## МАТЕМАТИК

Даалгаврын тоо	А хувилбар	Б Хувилбар	Онооны тайлбар
1	В	Б	1оноо
2	Б	А	1оноо
3	А	А	1оноо
4	Г	Б	1оноо
5	5дм	67мм	2оноо
6	А. хүснэгтэд зөв бүртгэх Б. Баганан диаграмм байгуулах		1оноо 2оноо